Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

## НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ӨСВӨР ҮЕ ЗАЛУУЧУУДЫН ЭРҮҮЛ МЭНД ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.МӨНГӨНЦЭЦЭГИЙН

## 2025 ОНЫ II УЛИРАЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшиг | Хүрэх түвшин /эхний хагас жил/ | Хүрсэн түвшин\биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | **Зорилт 1.Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний эрт илрүүлгийг нэмэгдүүлж, авчлөлөөс урьдчилан сэргийлэх, сэргийлж болох эндэгдлийг иргэд, хамт олны оролцоотой бууруулж, нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг эрчимжүүлэх** | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Өсвөр үе залуучуудын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэн ажиллах, Өсвөрийн клубын үйл ажиллагааг эрчимжүүлэх | Хэрэгжилтийн хувь | 60% | 95% | Өсвөр үеийнхэнд бэлгийн цогц боловсрол ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдлэг чадварыг шинэлэг хэлбэрээр эзэмшүүлж үе тэнгийн сургагч багш нарыг бэлтгэх, тэд нараар дамжуулан бусад сурагчдад мэдээлэл хүргэх зорилгоор “Бэлгийн боловсрол ба үе тэнгийн сургагч багш бэлтгэх” сургалтад 6-р сургуулийн 8-р ангийн 26 сурагч, тэдний сэтгэл зүйч болон Өнө Орших өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан, БОЭТ өсвөрийн эмч О.Анарням нар оролцсон.<br>Энэхүү сургалтын зорилго нь өсвөр үеийнхэнд:<br>• Бэлгийн цогц боловсрол<br>• Нөхөн үржихүйн эрүүл мэнд (НҮЭМ)<br>• Бэлгийн замаар дамжих халдварууд (БЗДХ)<br>гэсэн чухал мэдлэг, чадварыг шинэлэг, сонирхолтой хэлбэрээр олгож, үе тэнгийнхээ дунд зөв мэдээлэл түгээж чадах сургагч багш болгон бэлтгэхэд оршино.<br><br>Сургалтын 2 дахь өдөр:<br>Гэр бүл төлөвлөлт,<br>Жирэмслэхээс хамгаалах арга-Орчин үеийн арга,<br>Хүний эрх ба жендэр сэдвүүдээр сургалт зохион байгуулагдаж, мэдээлэл хүргэж ажиллалаа. | 2-12 сар | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Сургалтын үндсэн чиглүүлэгч багшаар "Хамтдаа" ТББ-ын тэргүүн, Нийгмийн ажилтан-Сэтгэл зүйч, Нийгмийн ажлын магистр, Сэтгэл судлалын докторант, Бэлгийн цогц боловсролын үндэсний эксперт Ш.Галбадрах оролцлоо. | | |
| 2. | Арга хэмжээ 1.2. Эрүүл мэндийг дэмжигч ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах | Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо | - | 90% | 3-р улиралд зохион байгуулагдахаар төлөвлөж байна. | 2-12 сар | - |
| 3. | Арга хэмжээ 1.3. Ерөнхий боловсролын сургууль, коллежийн сурагчдын дунд Эрүүл мэндийн олимпиад зохион байгуулах | Олимпиадын үнэлгээ | 0 | 90% | Говийн оюу хөгжлийг дэмжих сангаас 13,217,000 төгрөгийг шийдвэрлүүлэн ЭРҮҮЛ АЖ ТӨРӨХҮЙ эрүүл мэндийн массын олимпиадыг 2025 оны 03 сарын 20,21-ны өдрүүдэд зохион байгуулж ажиллалаа Олимпиадад нийт 15 сумын 22 сургуулийн 6-12 дугаар ангийн 3103 суралцагч, бага, дунд ангийн 56 багш өрсөлдсөн. Аймгийн хэмжээнд нийт 6-12 дугаар ангийн 3103 суралцагч оролцохоос 2794 суралцагч оролцож 90% ийн ирцтэй гүйцэтгэлийн хувь 48.3% байлаа. 6-12 дугаар ангиудын гүйцэтгэлийн хувийг тус тусад нь авч үзэхэд 12 дугаар анги хамгийн өндөр гүйцэтгэлтэй буюу 65.8%тай байхад хамгийн бага гүйцэтгэлтэй нь 6 дугаар анги буюу 39.3% байсан. Энэ нь цахим тоног төхөөрөмжтэй харилцах харьцаа болон, багш нарын ур чадвартай хамааралтай юм. Эрүүл мэндийн массын олимпиадыг анги тус бүрээр гүйцэтгэлийг гаргаснаас гадна нийт ангийн дундажаар сургуулийн дундажийг гаргав. 22 сургуулиас 8 сургууль нь аймгийн дундажаас дээгүүр үнэлэгдсэн байна. **ОЛИМПИАДЫН ДҮГНЭЛТ:** | 4 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 1. Эрүүл мэндийн хичээл нь 6 агуулгын хүрээнд анги бүрт давтагдан хүндэрч ирдэг болович нөхөн үржихүй, анхны тусламжийн агуулгын дагуу боловсруулсан асуултыг андуурах асуудал нилээн элбэг тохиолдсон байна.<br>2. Эрүүл мэндийн хичээлийг нэг багш дагнан заах нь илүү үр дүнтэй нь энэ олимпиадын гүйцэтгэлээс харагдаж байна. Даланзадгад сумын 3 дугаар сургууль нэг багш дагнан заадаг нь анги бүрийн гүйцэтгэл болон Шүд угаах олимпиадын гүйцэтгэлээс тодорхой үр дүн гарч байгаа нь ажиглагдаж байна.<br>3. Биологийн багш болон сургалтад хамрагдсан багш нарын гүйцэтгэл өндөр байна.<br>4. Олимпиадын гүйцэтгэлийг анги нийтээрээ нэгэн зэрэг илгээх үзэгдэл ажиглагдаж байгаа нь хуулсан байх магадлалтайг илэрхийлж байна. Цаг минутын хувьд бүгд тэмдэглэгдэж байгаа тул нэгэн зэрэг илгээсэн нь харагдаж байна.<br>5. Сургалтын хөтөлбөрийн дагуу сэдвийг боловсруулсан тул багш бүр тухайн 40 минутыг үр бүтээлтэй зааж сургах нь чухал гэдгийг илтгэж байна.<br>6. Эрүүл мэндийн хичээл нь зөв дадал хэвшилтэй зөв монгол хүн болгох зорилготой тул оролцооны аргад тулгуурлан хичээл бүрийг сонирхолтой аргаар заах, бие даасан үйл | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллагаа, зөв дадал хэвшил бий болгох туршилтуудыг хийх нь суралцагчдын сонирхлыг татсан хичээл болох нь харагдаж байна.<br>7. Багш төвтэй бус суралцагч төвтэй хичээл заах нь чухал байна.<br>8. Medlee.mn-ийн хичээлийн туршилт, арга зүйгээр хичээлийг төлөвлөн заах нь үр дүнд хүрэхийг илтгэж байна. | | |
| 4. | Арга хэмжээ 1.4. Оюутны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах | Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан оюутны тоо | - | - | Бүсийн оношилгоо эмчилгээний төвтэй хамтран ШУТИС-ын Өмнөговь аймаг дахь салбар технологийн сургуулийн киосын 1 2 дугаар дамжааны 90 хүүхдийг халдварт өвчний үзлэг шинжилгээнд хамруулж ажилласан. Жаргалтай ирээдүй хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэгийн насанд дараа жил төгсөж оюутан болох залуус 17 насыг оруулж өгөн 17 насны 938 хүүхдийг үзлэгт хамруулахаар төлөвлөн үзлэг 05 сарын 19-ний өдрөөс хийгдэж ажиллаж байна. | 9-12 сар | 70% |
| 5 | Арга хэмжээ 1.5. Ерөнхий боловсролын сурагчдад чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах | Сургалтад хамрагдсан хүний тоо | - | 500 | Даланзадгад сумын 3 усргуулийн 150 сурагчид тамхины хор хөнөөлийн талаарх сургалтыг зохионб айгуулж ажилласан. Ноён, Гурвантэс сумын 400 сурагчид өсвөр үеийн эрүүл мэндийн талаарх мэдлэг ойлголт суулгах сургалтыг зохион байгуулж ажиллалаа. Өмнөговь аймгийн Засаг даргын санаачилсан "Электрон тамхинаас татгалзаж, ирээдүйгээ хамгаалцгаая" аяныг 1 сарын хугацаанд амжилттай зохион байгуулагдан аянд хамтарч ажилласан. Аяны хүрээнд 3 сум, 6 сургуулийн 1000 орчим сурагчдад электрон тамхины хор хөнөөлийн талаар сургалтыг зохион байгуулж ЕБС-н тамхины хэрэглээний талаарх судалгааг авч дүгнэлт гаргаж ажиллалаа. 2025 оны байдлаар 10-с дээш насны 15 сургуулийн 1255 сурагчаас судалгаанд хамрагдсан.<br>Өсвөр үеийнхнийг сонсъё, ойлгоё" сэдэвт өсвөр үеийнхний эрүүл мэндийг дэмжих сарын аяныг 4 сарын 15-с 5 сарын 15-ны хооронд зохион байгуулж нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагааг эрүүл мэндийн газрын цахим хаягаар иргэдэд хүргэж, | 2-12 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Дархлаажуулалтын 7 хоногийн аянтай хамтран Даланзадгадын 6 сургуулийн 3000 хүүхдэд өртөөчилсөн мэдээлэл хүргэж танин мэдэхүйн асуумжаар мэдлэг шалгаж ажилласан. Зөв, зохистой хооллолт, идэвхтэй хөдөлгөөний дадал эзэмшүүлэх, бэлгийн бойжилт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэнд, хорт бодисын хэрэглээ, хүчирхийллийн улмаас тохиолдож буй бэрхшээл, асуудлыг шийдвэрлэх, эрсдэлт зан үйлээс татгалзах арга ухаанд суралцахад нь туслах чиглэлээр Ноён, Гурвантэс суманд ажиллаж 6-12 дугаар ангийн нийт 400 сурагчид сургалт мэдээллийг хүргэж "Өсвөр үеийнхнийг сонсъё, ойлгоё" сэдэвт уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж ажилласан. | | |
| 6. | Арга хэмжээ 1.6. Өсвөр үед ээлтэй клиникүүдийн үйл ажиллагааг удирдлага арга зүй, дэмжлэгт хяналт хийх | Арга зүйгээр хангагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо | - | 2 | БОЭТ-н өсвөр үеийн кабинеттэй хамтран ажиллаж байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн өсвөр үеийн кабинет 2025 оны 5 сарын байдлаар 498 хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж ажиллалаа. Үүнээс: Бэлгийн хүчирхийллийн шинжтэй – 10<br>Тэмбүү – 16<br>Заг хүйтэн – 6<br>Умайн хүзүүний үрэвсэл болон бусад үрэвслийн шалтгаант өвчлөлтэй холбоотой 22 тохиолдлыг эмчлэн эрүүлжүүлсэн.<br>Бусад – 444 тохиолдол урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдсан.<br>Цаашид эмч нарыг ажлын байран дээрх дагалдан сургалт явуулахаар ЭХЭМҮТ-н чанарын албатай холбогдон ажиллаж байна. | 2-12 сар | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | Арга хэмжээ 1.7 Аймгийн хэмжээнд 4,6,8,10,12,14,16 насны хүүхдийн багцын урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах | Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь | 62 | 40 | Аймгийн хэмжээнд 4,6,8,10,12,14,16,17 хүртэлх насны 12243 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүл мэндийн байдлыг үнэлэн, мэргэжлийн эмчийн хяналтад авч цаашид эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөөд 2025 оны 05 сарын 05 ны А/572 захирамжаар 287,714,000 төгрөгийг шийдүүлэн Жаргалтай ирээдүй хүүхдийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг 05 сарын 19-ны өдрөөс эхлүүлэн үзлэгийн бүртгэл тайланг Вингс прораммын дагуу бүртгэж нэгдсэн тайлан мэдээг авхаар гэрээ байгуулан ажиллаж байна. Ханбогд, Гурвантэс, Булган, Хүрмэн, Баяндалай СЭМТ, Шимбилиг ӨЭМТ Жаргалтай ирээдүй үзлэгээ эхлүүлэн бүртгэлээ хийн ажиллаж байна. Одоогийн байдлаар 1187 хүүхэд үзлэгт хамрагдсан үзлэгийн хмрагдалт 9 хувийн гүйцэтгэлтэй байна. | 4- 12 сар | 40% |
| 8. | Арга хэмжээ 1.8 Өсвөр үеийхний тамхидалт, электрон тамхины хэрэглээний талаарх судалгааны ажил зохион байгуулах | Судалгаанд хамрагдсан өсвөр үеийнхний тоо | - | 1000 | Өмнөговь аймгийн 13 сургуулийн 10-18 насны 1250 сурагчаас 2025 оны /04 сараас 05сар/ 1 сарын хугацаанд Google forms ашиглан нэг агшингийн судалгааны загвараар, Үр дүнгийн статистик боловсруулалтыг STATA 23.0 программ ашиглан гүйцэтгэж Нэг, хоёр сорох байдлаар татахыг оролдож үзсэн байдалд дүгнэлт хийхэд янжуур тамхи сонирхох байдал 14,6% /182/, электрон тамхи сонирхох байдал 32,1% /398/ буюу 17,5% 216 тохиолдлоор өндөр байна. Янжуур тамхи татдаг сурагч 55, электрон тамхи татдаг сурагч 126 байгаа нь электрон тамхины хор нөлөөг өсвөр насны хүүхдүүд мэдэхгүйгээр донтох эрсдэлтэйг харуулж байна. Насны хувьд 14 насанд янжуур тамхи татдаг тохиолдол хамгийн өндөр /14/ байгаа бол Электрон тамхи 14 наснаас эхлэн 17 насны хүүхдүүд хамгийн ихээр /105/ татаж байна. 16 насны сурагчдын электрон тамхи таталтын хувьд эрэгтэй эмэгтэй 9/11 байгаа нь электрон тамхийг хүйс харгалзахгүй татаж байгааг харуулж байна. | 4-12 сар | 100% |
| 9. | Арга хэмжээ 1.9 Өөрийн байгууллага болон бусад байгууллагаас эрүүл мэндийн боловсрол | Байршуулсан мэдээллийн тоо | 0 | 10 | Байршуулсан мэдээллийн тоо 16 | 2-12 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | олгоход чиглэгдсэн сургалтуудын талаарх мэдээллийг орон нутгийн болон байгууллагын цахим хуудсанд байршуулан мэдээллийн сан үүсгэх | Хандалтын тоо | 0 | 10000 | Хандалтын тоо 9,500 | | |
| 10. | Арга хэмжээ 1.10 Ерөнхий боловсролын сургуулийн эмч, дотуур байрны багш, биеийн тамирын багш нарт эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулах | Сургалтад хамрагдсан ажилчдын тоо | 20 | 30 | 3-р улиралд зохион байгуулагдана. | 2-12 сар | - |
| 11. | Арга хэмжээ 1.11 Байгууллага хамт олны дунд биеийн тамир чийрэгжүүлэлт дасгал хөдөлгөөнийг идэвхжүүлэхэд чиглэсэн Шугаман бүжгийн тэмцээн зохион байгуулах | Үйл ажиллагаанд оролцсон хүний тоо | 0 | 300 | Эрүүл Монгол Хүн Үндэсний хөдөлгөөн аяны хүрээнд зохион байгуулагдаж буй "Бөн бөн" бүжгийн цахим уралдаан Өмнөговь аймгийн ард иргэдийн дунд нээлттэй зохион байгуулагдаж 27 багийн 270 гаруй иргэд оролцлоо. Нэгдсэн дүн: Байгууллага: 1-р байр / Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар/ 2-р байр / Цогтцэций сум 6-р цэцэрлэг/ 3-р байр /Эрүүл мэндийн газар/ Хамтлаг: 1-р байр / Хот айл хамтлаг / 2-р байр / Солонго хамтлаг / 3-р байр / Дэлбээ хамтлаг / Ахмад үе: 1-р байр / Гэрэлт-1 хамтлаг /2-р байр / Ахмадын жавхаа хамтлаг / 3-р байр / Алтанзул хамтлаг / тус тус шалгарсан байна. | 2-8 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12. | Арга хэмжээ 1.12 Бүх шатны боловсролын байгууллагын чөлөөт цаг, хичээлийн бус цагаараа бие бялдараа чийрэгжүүлэх, биеийн тамираар хичээллэх нөхцөл бололцоог хангахад чиглэсэн Завсарлагааны хэмнэл арга хэмжээг зохион байгуулах | Сургуулийн тоо | 34 | 34 | Сүүлийн жилүүдэд дэлхий нийтэд 2 дугаар хэлбэрийн чихрийн шижин өвчин хурдацтай өсөж байгаа бөгөөд, хүүхэд өсвөр үеийнхэнд ч тохиолдох болсон. Хүүхэд өсвөр наснаасаа идэвхтэй хөдөлгөөн хийж хэвших нь тэдний амьдралын насан туршийн зөв дадал болон хадгалагдах үндэс болдог. Иймээс нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, идэвхтэй хөдөлгөөний ач холбогдлыг хүн амд сурталчлах, хэвшүүлэх, хүүхэд өсвөр үеийнхнийг чийрэгжүүлэх, дасгал хөдөлгөөнийг тэдний амьдралын дадал хэвшил болгох хүүхэд, залууст идэвхтэй хөдөлгөөний ач холбогдлын талаар сурталчлах, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх таатай орчныг бүрдүүлэх зэрэг асуудлуудыг нэн тэргүүнд шийдвэрлэн, дэмжиж ажиллах шаардлага хэрэгцээ байгаа учир Сургууль, цэцэрлэг, боловсролын байгууллагуудын дунд идэвхтэй дасгал хөдөлгөөнийг дэмжсэн уриалга, нөлөөллийн цогц арга хэмжээ Завсарлагааны хэмнэл аяныг сургууль, цэцэрлэг гэсэн 2 ангилалаар 05 сарын 01-ний өдрөөс 11 сарын 1-ний өдөр хүртэл зохион байгуулан ажилаж байна. | 3-11 сар | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 13. | Арга хэмжээ 1.13 Хүн амын хөдөлгөөний хомсдол, бие бялдарын хөгжлийн түвшинг тандан судлах, орон нутгийн хүн амын бие бялдарын чийрэгжилтийн түвшинг тогтоох, судалгааны үр дүнг хянах, тайлагнах. | Судалгаанд хамрагдсан иргэний тоо | 0 | 200 | Хүн амыг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, тогтмол идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээлэх, бүх нийтийн дугуйн хэрэглээг нэмэгдүүлэх, эрүүл зан үйл, хандлага төлөвшүүлэх зорилгоор Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дунд Дугуйтай аяныг 05 сарын 1-ний өдрөөс 09 сарын 1-ний өдөр хүртэл зохион байгуулан ажиллаж байна. Үйл ажиллагааг идэвхжүүлж ЭМГ-н цахим хаягт мэдээлэл оруулж байна. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын дунд идэвхитэй хөдөлгөөнийг дэмжих чиглэлээр Эрүүл мэндийн салбарын Дундговь аймагт зохион байгуулагдсан бүсийн тэмцээнд 50 гаруй эмч мэргэжилтнүүд оролцож амжилттай оролцож Улаанбаатарруу 10 гаруй тамирчин оролцсон. Эмч нарын баяр, Сувилагч нарын баяртай холбогдуулан гар бөмбөг дартсын тэмцээнүүд зохион байгуулагдаж 180 гаруй эмч мэргэжилтнүүд оролцож идэвхтэй дасгал хөдөлгөөнийг эрхэмлэж ажиллалаа.<br>131 төрийн албан хаагчаас идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх судалгааг аван боловсруулалт хийгдэж байна. Цаашид нэмэгдүүлж 200 хүнээс судалгааг авч нэгтгэн дүгнэхээр төлөвлөсөн. | 6-10 сар | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 14. | Арга хэмжээ 1.14 Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд идэвхжүүлж, хамтран ажиллах | Үнэлгээнд хамрагдсан байгууллагын тоо | 0 | 10 | 3-р улиралд зохион байгууландана. | 6-9 сар | - |
| 15. | Арга хэмжээ 1.15 Эмнэлгийн мэргэжилтүүдийг өсвөр үед үзүүлэх тусламж үйлчилгээний чиглэлээр сургаж, чадавхжуулах | Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо | - | - | 3-р улиралд зохион байгуулагдана. | 3-12 сар | - |
| 16. | Арга хэмжээ 1.16 Хамгийн чухал нь эрүүл мэнд салбарын тэмцээнийг хамтран зохион байгуулж ажиллах | Арга хэмжээнд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо | - | 10 | 3-р улиралд зохион байгуулагдана. | 4 сар | - |

## ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хэрэгжүүлэх ажил | Эхлэх, дуусах огноо | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 2.1** Чиг үүргийн дагуу холбогдолтой шинээр батлагдсан хууль тогтоомж, эмнэлзүйн заавар, тушаал, журмыг уншиж судлан дагаж мөрдөн хэрэгжилтийг хангана. | Хууль тогтоол тушаал журмын хэрэгжилтийг хангаж ажиласан байдал | 90% | 100% | Чиг үүргийн дагуу холбогдолтой шинээр батлагдсан хууль тогтоомж, эмнэлзүйн заавар, тушаал, журмыг уншиж судлан дагаж мөрдөн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 4-12 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | **Арга хэмжээ 2.2** Өөрийн ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу шаардлагатай цахим болон танхимын сургалтад хамрагдана. | Оролцсон сургалт, үйл ажиллагааны тоо | 90% | 100% | Дотоод танхим сургалт – 10<br>Цахим сургалт – 6<br>АШУҮИС-н Орчны эрүүл ахуйн мэдлэг дээшлүүлэх олгох сургалтад хамрагдаж байна. | 4-12 сар | 100% |
| 3 | **Арга хэмжээ 2.3** Төрийн албаны тусгай шалгалт өгч төрийн жинхэнэ албан хаагчаар ажиллана. | Шалгалтын үнэлгээ | 60% | 80% | Төрийн албаны ажлын байрны тусгай шалгалт зарлагдсаны дагуу 2 сарын 10-ны өдөр Өсвөр үе залуучуудын эрүүл мэнд хариуцсан мэргэжилтнээр шалгалт өгч 79,3 оноогоор тэнцсэн. | 2 сар | 100% |
| 4 | **Арга хэмжээ 2.4** Эрүүл мэндийн байгууллагын хэвтэн эмчлүүлэгчийн өрөөний шалны алчуураас MRSA илрүүлэх судалгааны ажил хийх | Судалгааны үр дүн | - | - | Удирдамж боловсруулан ажиллаж байна. | 8-11 сар | - |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Өсвөр үе залуучуудын эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн Б.Мөнгөнцэцэг / ......................... / 2025.06.20